



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/460

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а" заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 74 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.4.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Ховд брэнд бүтээгдэхүүн"-ийг жил бүрийн "Ховдын хөгжил" үзэсгэлэн худалдааны үеэр шалгаруулж байсугай.

2."Ховд брэнд бүтээгдэхүүн"-ийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай .

Ажлын хэсгийн дарга : Аймгийн Засаг даргын орлогч

- Гишүүд:
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
  - Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
  - Аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн дарга
  - Аймгийн худалдаа аж үйлдвэрийн танхимын төлөөлөл
  - Аймгийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн төлөөлөл

Нарийн бичгийн  
дарга :

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

3. "Ховд брэнд бүтээгдэхүүн"-ий сонгон шалгаруулалтыг аймгийн хэмжээнд нээлттэй зохион байгуулж , хэрэгжилтийг ханган ажиллахыг ажлын хэсгийн дарга / Т.Жаргалсайхан /-д үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

-Zax A/460 Ch  
02 02279